

# Даян Дэлхийн Байгаль Орчны Сан/НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөр Нүүдлийн цаачид олон улсын төсөл

*Цаачдын амьжиргаа болон экосистемийн уян хатан чанарыг сайжруулах нь*

## Яагаад төсөл чухал вэ

Өнөөдрийн байдлаар Монгол болон ОХУ-ын тайгын бүс нутагийн биологийн олон янз байдалд аюул занал нүүрлэн, газрын доройтол нэмэгдэж, цаа буга маллагчдын тогтвортой амьжиргаа баталгаагүй байсаар байна. Өөрчлөгдөн буй нийгэм эдийн засаг, дэлхийн цаг уурын дулаарал зэрэг нь тухайн бүс нутагт амьдарч буй иргэд болон тайгын экосистемийн уян хатан чанар, түүний дасан зохицох чадварт сөргөөр нөлөөлж байна. Эрдэмтдийн хийсэн судалгаагаар 2050 он гэхэд 5°C-ээр дулаарна гэсэн тооцоо байдаг. Хэрвээ эдгээр асуудлуудад одооноос эхлэн анхаарлаа хандуулж, холбогдох арга хэмжээг авахгүй бол орчны доройтол нэмэгдэж улмаар биологийн олон янз байдал, тэр тусмаа ховордож, устаж буй төрөл зүйлүүд мөхөж, цаа буга маллагч иргэдийн соёлын болон материаллаг баялаг үгүй болно.

## Зорилго, зорилт болон фокус

Даян Дэлхийн Байгаль Орчны Сан/НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжих “Нүүдлийн цаачид” олон улсын төсөл нь ОХУ болон Монголын хойд хэсгийн цаа бугын бэлчээр нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын доройтлыг бууруулах арга замыг тодорхойлох замаар цаачин иргэдийн амьжиргаа, хүрээлэн буй орчны уян хатан чанарыг сайжруулахыг **гол зорилгоо** болгож байна.

Төслийн үндсэн хандлага нь байгаль хамгаалах үйл ажиллагаанд цаачин иргэдийн оролцоог нэмэгдүүлж улмаар тэр иргэдийн амьжиргааг урт хугацааны турш тогтвортой байлгахад чиглэгдэнэ. Нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг чадвар нь энэхүү төслийн салшгүй хэсэг байна. Төслийн бас нэг онцлог нь нутгийн иргэдийн байгаль хамгаалах чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа бөгөөд тухайн орон нутагт тохирсон, доороос дээш чиглэгдсэн оролцоонд тулгуурласан байна. Түүнчлэн төслийн хүрээнд Цаа буга маллагчдын төв мэдээллийн байгуулж орон нутгийн иргэдийн чадавхийг дээшлүүлэх болно. Цаачид төслийн үйл ажиллагаанд гар бие оролцож байгаль хамгаалах механизмыг хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

Олон улсын туйлын жилийн хүрээнд хэрэгжсэн **EALÁT** төслийн залгамж: “Нүүдлийн цаачид” олон улсын төслийн саналыг анх 2009 онд Дэлхийн Цаа буга маллагчдын холбооноос гаргасан бөгөөд тухайн үед Олон улсын туйлын жилийн хүрээнд амжилттай хэрэгжсэн **EALÁT** төслийн үргэлжлэл болно гэж тодорхойлсон. **EALÁT** төсөл нь ОХУ, Монгол улс болон Арктикийн бүс нутгийг бүхэлд нь хамарсан бөгөөд цаа маллагчдын уламжлалт мэдлэлийг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулах замаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нутгийн иргэдийн оролцоотой 10 уулзалт зохион байгуулсан бөгөөд үүнээс ОХУ-ын Саха (Якут) Улсад 8 удаа, Монгол 2 удаа тус тус зохион байгуулсан.

**Даян Дэлхийн Байгаль орчны сангийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж буй байдал:** Төслийн үйл ажиллагаа нь Даян Дэлхийн Байгаль орчны сангийн газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах мөн тусгай хамгаалалттай газар нутгийг бэхжүүлэх зорилтуудтай бүрэн нийцэж байгаа болно. Үүнд:

- ☉ Газрын доройтол LD-1 (нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих агро-экосистемийн үйлчилгээний урсацыг сайжруулах буюу дээшлүүлэх)
- ☉ Газрын доройтол LD-3 (газар ашиглалтаас байгалийн нөөц баялагт үзүүлж буй дарамт шахалтыг бууруулах)
- ☉ Биологийн олон янз байдал BD-2 (үйлдвэрлэлийн салбарын бодлогод биологийн олон янз байдлын хамгаалал болон тогтвортой ашиглах асуудлыг тусгах)

## Төслийн үр дүн

Төслөөс үндэсний болон дэлхийн хэмжээнд гарах үр дүнг тодорхойлбол:

- ☉ Дэлхийн болон бүсийн хэмжээнд ховордож, устах аюул нүүрлэн буй зарим биологийн олон янз байллын хамгаалахал оновчтой ангачлал боловсруулж хэрэгжүүлэх

- Ⓞ Бэлчээрийн хуваагдал, доройтол болон хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулах аргачлалын боловсруулж хэрэгжүүлэх
- Ⓞ ЮНЕСКО-ийн өвд цаа бугын аж ахуйн бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Ⓞ Хойд туйл орчмын соёлын өв болсон Цаа бугын аж ахуйг хамгаалж, хөгжүүлэх
- Ⓞ Уламжлал, нүүдлийн соёл иргэншил болон биологийн олон янз байдлын хамгааллыг хослуулсан тэргүүн туршлага бий болгох
- Ⓞ Уугуул хэл соёлыг биологийн төрөл зүйллийн хамгаалалтай хослуулан хадгалах
- Ⓞ Уламжлалт цаа бугын аж ахуйг эрхлэж, цаачид байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох боломж бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангилал бий болгох боломжийг судлах
- Ⓞ Цаа буга маллагчдын мэдээллийн төв байгуулж байгаль хамгаалах, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

### Хэрэгжүүлэх аргачлал, зарчим

**Төслийн загвар газар нутаг:** Төсөл нь цаачин иргэд амьдарч буй ОХУ-ын Якутын өмнөд хэсэг, Монголын Хөвсгөл аймгийн хойд хэсгийг хамран бөгөөд доорхи үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ:

**Боловсруулах үе шат (Бүрэлдэхүүн 1):** Газар ашиглалт, биологийн олон янз байдлын нөөц, хандлага, газар зохион байгуулалтыг хийхэд нутгийн иргэдийн уламжлалт мэдлэгийг орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилттай хослуулах замаар *хялбарчилсан аргачлал* боловсруулах. Энэ ажлын хүрээнд хүрээлэн буй орчин, биологийн олон янз байдал, цаа бугын аж ахуйн талаарх уламжлалт болон шинжлэх ухааны мэдлэгийг газар зүйн мэдээллийн систем ашиглан нэгтгэнэ. Түүнчлэн байгаль орчны хэтийн хандлагыг тодорхойлж шаардлагатай арга хэмжээг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

**Хэрэгжүүлэх үе шат (Бүрэлдэхүүн 2):** Дээр тайлбарласан аргачлалыг “хийх явцдаа суралцах” замаар хэрэгжүүлнэ. Энэ нь орон нутгийн иргэдийн оролцоог бүрэн хангасан байх бөгөөд биологийн төрөл зүйлийн хамгааллын асуудлын боловсронгуй болгох түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ уулзалт яриа, түншлэл, хамтын мониторинг болон дасан зохицох аргачлыг ашиглана.

**Урт хугацааны ядавхи бий болгох (Бүрэлдэхүүн 3):** Төслийн хүрээнд нэн шаардлагатай чадавхжуулах сургалт, уулзалт болон ухуулга сурталчилгааны ажлууд зохион байгуулагдаж орон нутгийн иргэдийн мэдлэг чадварыг нэмэгдүүлнэ. Төслийн хүрээнд ОХУ болон Монгол улсад цаа маллагч иргэдэд зориулсан мэдээллийн төв байгуулагдах бөгөөд үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан сургалт семинарыг тогтмол зохион байгуулна. Сургалтууд нь байгаль хамгаалах чиглэлтийг түлхүү баримтлах боловч цаа маллагч иргэдийн амьжиргааг дээшлүүлэх үүднээс гар урлал, аялал жуулчлал эрхлэх чиглэлээр өөр бусад сургалтуудыг тогтмол зохион байгуулна.

**Олон улсын хамтын ажиллагаа болон туршлагаа хуваалцах (Бүрэлдэхүүн 4):** Олон улсын хэмжээнд хамтын ажиллагаа бий болгоход Цаа бугын аж ахуйн олон улсын төв болон GRID Арендал байгууллагууд зохицуулах үүргийг гүйцэтгэнэ. Төслийн хүрээнд бий болсон ололт амжилтууд нь хөрш зэргэлдээ улс оронд төдийгүй дэлхийн өөр өнцөг буланд цаа бугын аж ахуй эрхлэж буй ард иргэдэд чухал хувь нэмэр үзүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд олон төрлийн хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг болон танилцах ялалууд зохион байгуулагдана. Түүнчлэн, төслийн төлөөлөл биологийн төрөл зүйлийн хамгааллын чиглэлээр олон улсын хэмжээний уулзалт зөвлөгөөнд (Биологийн олон янз байдлын конвенцийн хурлууд, НҮБ-ын Уугуул иргэдийн асуудлаарх байнгын хорооны хурал, ЮНЕСКО болон Арктикийн зөвлөлийн хурлууд гэх мэт) оролцох болно.

### Дүгнэлт

Төсөл хэрэгжих 4 жилийн хугацаанд “Нүүдийн цаачид” олон улсын төсөл нь хувьсан өөрчлөгдөж буй хүрээлэн буй орчинд тохируулах, нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цаачдын амьжиргааг дээшлүүлэхэд

үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Түүнчлэн НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөртэй хамтран Монгол улсын Засгийн газраас байгаль хамгаалах чиглэлээр баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно.

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн “Нүүдлийн цаачид” төсөл нь нутгийн уугуул иргэд өөрсдөө санаачилсан, орон нутгийн засаг захиргаа болон өөр бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх онцгой төсөл бөгөөд төслийн хүрээнд ОХУ болон Монголын цаа буга бүхий тайгад байгаль хамгаалал сайжирч, газрын доройтол буурсан байх ба цаа маллагч нутгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна.

### **Холбоо барих хаяг**

#### **Монгол дахь Үндэсний Зохицуулагч**

Пүрэвийн Цогтсайхан

Тайгын байгаль нийгэмлэгийн тэргүүн

Монгол Улс, Улаанбаатар-46, Шуудангийн хайрцаг 183, Баянгол дүүрэг, 15-р хороо

Утас: 976-11-310317, 976-99075559

И-мэйл хаяг: [montaiganature@gmail.com](mailto:montaiganature@gmail.com)

#### **Орос дахь Үндэсний Зохицуулагч**

Михаил Погодаев (PhD)

Санкт Петербург дэхь Цаа бугын аж ахуйг хөгжүүлэх холбоо болон Цаа маллагчдын олон улсын төвийн салбар

Невскийн өргөн чөлөө, 128А, Санкт Петербург хот, ОХУ, 121024

Утас: +78123237168, +79119169780

И-мэйл хаяг: [pogodaevm@gmail.com](mailto:pogodaevm@gmail.com)

#### **Олон улсын Зохицуулагчид**

Профессор Свейн Диш Майтиесен

“Нүүдлийн Цаачид” Төслийн багийн ахлагч

UArctic EALAT институт, Цаа буга маллагчдын олон улсын төв

Утас: +47 905 24116,

И-мэйл хаяг: [svein.d.mathiesen@gmail.com](mailto:svein.d.mathiesen@gmail.com) [www.reinportal.org](http://www.reinportal.org) [www.reindeerblog.org](http://www.reindeerblog.org)

Бёрн Алфтан

“Нүүдлийн Цаачид” Төслийн менежер

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр/ГРИД Арендал

Утас: +47 907 344 32

И-мэйл хаяг: [bjorn.alfthan@grida.no](mailto:bjorn.alfthan@grida.no)